

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/188/НА-СТА-ТШЗ

Чингис хот

2025 он

Цахим хаяг: www.open.audit.mn

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим
хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг:
oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Х.Еркегүл
Утас: 99040705
Цахим хаяг: erkhegulkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12. Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.24 № 258

танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗООНОЗ
ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН
ДАРГА Ц.ГЭРЭЛМАА ТАНАА

Г Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн ЗӨСТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

Цалингийн зардлаас илүү цагийн нэмэгдэлд 7,370.0 мянган төгрөгийг үндэслэлгүй, ээлжийн амралтын цалин авсан 2 ажилтанд ээлжийн амралтаа биеэр эдлээгүй нэмэгдэлд 3,025.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон;

Байгууллагын даргад хяналт шалгалтын үнэлгээ, санхүүгийн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ зэрэг үзүүлэлтийг үндэслэн 5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буюу 8,360.0 мянган төгрөг, оны шилдэг тасаг, шилдэг ажилтнуудад 6,473.3 мянган төгрөг, нэг өмч-нэг бүртгэл аяны үр дүнг үндэслэн өмч хамгаалах байнгын зөвлөлд 1,017.6 мянган төгрөг, нягтлан бодогчид төрийн болон албаны нууц хамгаалах ажилтны нэмэгдэлд 1,425.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан, зардлын эдийн засгийн ангилал зөрчин олгосон;

Ханбүргэд номин ХХК-тай засвар үйлчилгээ хийлгэх гэрээ байгуулан засварын зардлаас 9,500.0 мянган төгрөг, цэвэр бохир усны зардлаас 4,800.0 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгө зарцуулж засварын ажил хийлгэсэн боловч гэрээг дүгнэж, хэрэгжилтийг тайлагнаагүй, засварын ажлын зураг төсөв гаргаагүй, цэвэр бохир усны зардлаас засварын зардал гаргаж батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг баримтлалгүй зардал хооронд шилжүүлэн зарцуулсан;

232520258

Энх антарис мэд ХХК-тай гэрээ байгуулан 6,000.0 мянган төгрөгийн халаалтын зуух худалдаж авсан боловч хөрөнгийг хүлээж авсан акт үйлдээгүй, техникийн ашиглалтын паспорт байхгүй, биет тооллого хийхэд уурын зуух нь эвдэрсэн зэрэг анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, төсвийн хөрөнгийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуультай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь тайлант онд орон нутгийн төсвөөс 986,431.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтээр 12,411.3 мянган төгрөгийн орлого, үндсэн үйл ажиллагаанаас 7,857.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 997,188.3 мянган төгрөгийг зарцуулан, 9,512.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 55,894.2 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 17,275.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 30,695.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 7,922.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүллээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 4 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, хэрэгжилт 94.8 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>255,679,405.17</u>	<u>366,204,855.38</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	812,991.63	
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	812,991.63	
3121	Төгрөг	812,991.63	
31213	Арилжааны банк дахь харилцах	812,991.63	
35	БАРАА МАТЕРИАЛ	228,366,013.54	339,704,455.38
351	Түүхий эд материал	201,977,933.54	283,792,075.38
35110	Тусгай зориулалттай материал	1,188,000.00	10,568,000.00
35130	Эм боох материал	200,789,933.54	273,224,075.38
354	Хангамжийн материал	26,388,080.00	55,912,380.00
35410	Бичиг хэргийн материал	4,212,800.00	4,536,600.00
35420	Аж ахуйн материал	22,175,280.00	50,027,780.00
35430	Сэлбэг хэрэгсэл		99,000.00
35440	Түлш, шатах тослох материал		1,249,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	26,500,400.00	26,500,400.00
36600	Бусад нөөц	26,500,400.00	26,500,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>992,939,687.64</u>	<u>1,173,912,308.07</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	992,939,687.64	1,173,912,308.07
392	Биет хөрөнгө	842,613,687.64	1,023,586,308.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	769,282,849.00	769,282,849.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(126,915,960.10)	(144,213,159.10)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,700,000.00	29,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(25,245,000.00)	(29,700,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	281,893,959.45	575,444,515.45
39206	Хуримтлагдсан элэгдэл	(86,957,160.99)	(183,833,897.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,462,170.60	14,662,170.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,607,170.32)	(7,756,170.31)
393	Биет бус хөрөнгө	150,326,000.00	150,326,000.00
39301	Програм хангамж	730,000.00	730,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(730,000.00)	(730,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	150,326,000.00	150,326,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,248,619,092.81</u>	<u>1,540,117,163.45</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		<u>96,260.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		96,260.00
413	Өглөг		96,260.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		96,260.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,248,619,092.81</u>	<u>1,540,020,903.45</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,248,619,092.81	1,540,020,903.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	235,269,309.00	235,269,309.00
51101	Өмч: - төрийн	235,269,309.00	235,269,309.00
512	Хуримтлагдсан үр дүн	911,204,870.11	1,202,606,680.75
51210	Өмнөх үеийн үр дүн	911,204,870.11	911,204,870.11
51220	Тайлант үеийн үр дүн		291,401,810.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	102,144,913.70	102,144,913.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,248,619,092.81</u>	<u>1,540,117,163.45</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	690,402,540.63	1,387,616,637.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,732,940.63	388,773,507.64
120	Нийтлэг татварын бус орлого	7,732,940.63	388,773,507.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,732,940.63	388,773,507.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,696,549.00	7,857,850.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,036,391.63	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	380,915,657.64
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	682,669,600.00	998,843,130.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	12,411,330.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	8,411,330.00
1330	Төсвийн захирагчдаас	682,669,600.00	986,431,800.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	682,669,600.00	986,431,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	756,937,030.67	1,096,214,827.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	756,937,030.67	1,096,214,827.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	738,048,662.32	1,084,852,675.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	467,086,217.13	718,312,823.65
210101	Үндсэн цалин	299,024,913.79	426,402,294.19
210102	Нэмэгдэл	127,637,231.63	192,257,707.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,887,000.00	34,488,832.85
210104	Урамшуулал	38,537,071.71	65,163,989.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,224,719.30	93,779,153.60
210201	Тэтгэврийн даатгал	39,974,560.12	62,305,672.11
210202	Тэтгэмжийн даатгал	4,658,834.30	6,926,083.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,878,818.02	7,574,162.93
210204	Ажилгүйдлийн даатгал	961,974.11	3,107,557.02
210205	Эрүүл мэндийн даатгал	8,750,532.75	13,865,677.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,070,839.22	24,140,532.42
210301	Гэрэл, цахилгаан	4,478,158.22	4,944,298.42
210302	Түлш, халаалт	8,591,770.00	11,734,200.00
210303	Цэвэр, бохир ус	5,000,911.00	7,462,034.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,098,597.00	27,045,355.00
210401	Бичиг хэрэг	966,300.00	5,426,030.00
210402	Тээвэр, шатахуун	16,236,700.00	15,150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	578,300.00	682,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,138,600.00	5,786,525.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	6,315,871.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	10,862,826.00	00.00
2105	Нормативт зардал	61,945,330.00	54,520,983.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	61,478,330.00	54,420,983.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	467,000.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,074,710.00	22,613,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	950,000.00

210604	Урсгал засвар	27,074,710.00	21,663,700.00
2107	Томилолт, зочны зардал	10,544,000.00	19,528,000.00
210702	Дотоод албан томилолт	10,544,000.00	19,528,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	605,120.00	321,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	207,724.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	331,800.00	258,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	33,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	29,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	65,596.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,399,129.67	124,590,927.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,223,400.00	812,991.63
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,175,729.67	123,777,935.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,888,368.35	11,362,151.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	451,000.00	1,849,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	451,000.00	1,849,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,437,368.35	9,512,551.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,437,368.35	9,512,551.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-66,534,490.04	291,401,810.64
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-66,534,490.04	291,401,810.64

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>690,402,540.63</u>	<u>1,006,700,980.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,732,940.63	7,857,850.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,732,940.63	7,857,850.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,732,940.63	7,857,850.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,696,549.00	7,857,850.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,036,391.63	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	682,669,600.00	998,843,130.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	12,411,330.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	8,411,330.00
1330	Төсвийн захирагчдаас	682,669,600.00	986,431,800.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	682,669,600.00	986,431,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>676,269,549.00</u>	<u>1,007,513,971.63</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	676,269,549.00	1,007,513,971.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	657,381,180.65	996,151,820.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	467,086,217.13	718,212,934.65
210101	Үндсэн цалин	282,024,913.79	426,302,405.19
210102	Нэмэгдэл	127,637,231.63	192,257,707.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,887,000.00	34,488,832.85
210104	Урамшуулал	38,537,071.71	65,163,989.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,224,719.30	93,782,782.60
210201	Тэтгэврийн даатгал	39,974,560.12	62,309,301.11
210202	Тэтгэмжийн даатгал	4,658,834.30	6,926,083.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,878,818.02	7,574,162.93
210204	Ажилгүйдлийн даатгал	961,974.11	3,107,557.02
210205	Эрүүл мэндийн даатгал	8,750,532.75	13,865,677.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,692,239.22	25,229,532.42
210301	Гэрэл, цахилгаан	4,478,158.22	4,944,298.42
210302	Түлш, халаалт	10,213,170.00	12,823,200.00
210303	Цэвэр, бохир ус	5,000,911.00	7,462,034.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,500,100.00	52,721,255.00
210401	Бичиг хэрэг	5,005,500.00	5,749,830.00
210402	Тээвэр, шатахуун	13,928,900.00	15,310,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	578,300.00	682,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,987,400.00	30,978,625.00
2105	Нормативт зардал	32,579,775.00	35,480,524.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,419,375.00	24,420,524.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,160,400.00	11,060,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,925,610.00	50,062,600.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	3,657,500.00	28,299,900.00
210604	Урсгал засвар	26,268,110.00	21,762,700.00
2107	Томилолт, зочны зардал	10,544,000.00	19,528,000.00
210702	Дотоод албан томилолт	10,544,000.00	19,528,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	605,120.00	321,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	207,724.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	263,200.00	258,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	34,300.00	33,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,300.00	29,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	65,596.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,223,400.00	812,991.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,223,400.00	812,991.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,888,368.35	11,362,151.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	451,000.00	1,849,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	451,000.00	1,849,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,437,368.35	9,512,551.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,437,368.35	9,512,551.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>14,132,991.63</u>	<u>(812,991.63)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,320,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,320,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	13,320,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	13,320,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(13,320,000.00)</u>	≡
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	812,991.63	(812,991.63)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		812,991.63
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	812,991.63	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,269,309.00	102,144,913.70	821,619,782.05	1,159,034,004.75
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	235,269,309.00	102,144,913.70	821,619,782.05	1,159,034,004.75
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	89,585,088.06	89,585,088.06
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,269,309.00	102,144,913.70	911,204,870.11	1,248,619,092.81
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,269,309.00	102,144,913.70	911,204,870.11	1,248,619,092.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	235,269,309.00	102,144,913.70	911,204,870.11	1,248,619,092.81
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	291,401,810.64	291,401,810.64
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,269,309.00	102,144,913.70	1,202,606,680.75	1,540,020,903.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	988,931,800.00	984,777,098.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	988,931,800.00	984,777,098.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	987,077,700.00	984,777,098.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	718,291,900.00	718,212,934.65
210101	Үндсэн цалин	427,162,100.00	426,302,405.19
210102	Нэмэгдэл	187,389,200.00	192,257,707.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,459,100.00	34,488,832.85
210104	Урамшуулал	65,281,500.00	65,163,989.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,018,400.00	93,782,782.60
210201	Тэтгэврийн даатгал	61,653,600.00	62,309,301.11
210202	Тэтгэмжийн даатгал	6,723,900.00	6,926,083.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,848,200.00	7,574,162.93
210204	Ажилгүйдлийн даатгал	1,344,800.00	3,107,557.02
210205	Эрүүл мэндийн даатгал	13,447,900.00	13,865,677.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,534,100.00	25,229,532.42
210301	Гэрэл, цахилгаан	4,981,100.00	4,944,298.42
210302	Түлш, халаалт	12,837,000.00	12,823,200.00
210303	Цэвэр, бохир ус	7,716,000.00	7,462,034.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,368,500.00	51,097,925.00
210401	Бичиг хэрэг	4,131,000.00	4,126,500.00
210402	Тээвэр, шатахуун	15,310,000.00	15,310,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	799,000.00	682,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	146,700.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,981,800.00	30,978,625.00
2105	Нормативт зардал	35,506,700.00	35,480,524.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,440,400.00	24,420,524.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,066,300.00	11,060,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,129,600.00	41,124,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,301,600.00	20,299,900.00
210604	Урсгал засвар	20,828,000.00	20,824,300.00
2107	Томиллолт, зочны зардал	19,577,200.00	19,528,000.00
210702	Дотоод албан томилолт	19,577,200.00	19,528,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	651,300.00	321,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,700.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	258,200.00	258,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,600.00	33,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,600.00	29,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	95,200.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,854,100.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,854,100.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,854,100.00	-
1310	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	988,931,800.00	984,777,098.67
131001	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	986,431,800.00	976,919,248.67
131001	Улсын төсвөөс санхүүжих	986,431,800.00	976,919,248.67
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,500,000.00	7,857,850.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,500,000.00	7,857,850.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,411,330.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,411,330.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,561,730.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,623,330.00
210401	Бичиг хэрэг	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,938,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000,000.00
210604	Урсгал засвар	938,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,849,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,849,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,849,600.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,411,330.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,411,330.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,411,330.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,411,330.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,411,330.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,561,730.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,623,330.00
210401	Бичиг хэрэг	1,623,330.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 55,894.2 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс 10,275.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 37,575.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 7,922.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

1. Цалингийн зардлаас илүү цагийн нэмэгдэлд 7,370.0 мянган төгрөгийг үндэслэлгүй, ээлжийн амралтын цалин авсан 2 ажилтанд ээлжийн амралтаа биеэр эдлээгүй нэмэгдэлд 3,025.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.

3.2 Албан шаардлага

1. Цалингийн зардлаас байгууллагын дарга хяналт шалгалтын үнэлгээ, санхүүгийн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ зэрэг үзүүлэлтийг үндэслэн 5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буюу 8,360.0 мянган төгрөг, оны шилдэг тасаг, шилдэг ажилтнуудад 6,473.3 мянган төгрөг, нэг өмч-нэг бүртгэл аяны үр дүнг үндэслэн өмч хамгаалах байнгын зөвлөлд 1,017.6 мянган төгрөг, нягтлан бодогчид төрийн болон албаны нууц хамгаалах ажилтны нэмэгдэл 1,425.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан, зардлын эдийн засгийн ангилал зөрчин олгосон;
2. Ханбүргэд номин ХХК-тай засвар үйлчилгээ хийлгэх гэрээ байгуулан засварын зардлаас 9,500.0 мянган төгрөг, цэвэр бохир усны зардлаас 4,800.0 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгө зарцуулж засварын ажил хийлгэсэн боловч гэрээг дүгнэж, хэрэгжилтийг тайлагнаагүй, засварын ажлын зураг төсөв гаргаагүй, цэвэр бохир усны зардлаас засварын зардал гаргаж батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг баримтлалгүй зардал хооронд шилжүүлэн зарцуулсан. Энх антарис мэд ХХК-тай гэрээ байгуулан 6,000.0 мянган төгрөгийн халаалтын зуух худалдаж авсан боловч хөрөнгийг хүлээж авсан акт үйлдээгүй, техникийн ашиглалтын паспорт байхгүй, биет тооллого хийхэд уурын зуух нь эвдэрсэн зэрэг анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, төсвийн хөрөнгийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулаагүй;

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Байгууллагын дарга нь өөрийн удирдлага доор ажиллуулан хяналт тавьдаг албан тушаалыг ЭМГ-ын даргын тушаалаар хавсран гүйцэтгэж байна. Тухайлбал Зооноз өвчин судлалын үндэсний төвийн 2016 оны А/31 дүгээр тушаалаар баталсан “Орон нутаг дахь ЗӨСТ-ийн бүтэц үйл ажиллагааны стандарт”-аар халдвар судлагч их эмч /тархвар судлагч/-ийн орон тооны доод хязгаар 2 байхыг аймгийн эрүүл мэндийн газарт орон тоо батлуулах саналаа 1.4-өөр хүргүүлж батлуулан, ажлын байрны сул орон тоог зарлаагүй, өөрөө хавсран гүйцэтгэж байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын бүтэц, орон тоог стандартад нийцүүлэн шинэчлэн тогтоож, ажлын байрны сул орон тоог олон нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулах арга хэмжээ авч ажиллах.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 1 сарын дотор, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алдаа илрээгүй												
Дүн	0	0.00										

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин илүү олгосон	2	27,671.4	1	10,395.5	1	17,275.9						
Мөнгөн хөрөнгийн зарцуулалт	1	20,300.0			1	20,300.0						
Дүн	3	47,971.4	1	10,395.5	2	37,575.9						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Зөрчил илрээгүй	0	0.00						
Дүн	0	0.00						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Орон тоо, цалин	1	7,922.8					1	7,922.8
Дүн	1	7,922.8					1	7,922.8
Нийт дүн	1	7,922.8					1	7,922.8



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 91-ХЭА-2025/188/НА-СТА-ТШЗ
А 83900 49

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлаас илүү цагийн нэмэгдэлд 7,370.0 мянган төгрөгийг үндэслэлгүй, ээлжийн амралтын цалин авсан 2 ажилтанд ээлжийн амралтаа биеэр эдлээгүй нэмэгдэлд 3,025.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "Хуульд тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2-р хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно." гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндэслэлгүй олгосон илүү цагийн 7,370.0 мянган төгрөг, давхардуулан олгосон 3,025.0 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дарга Ц.Гэрэлмаа, нягтлан бодогч Б.Амгаланбаатар нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ж.ГАНБААТАР
Х.ЕРКЕГҮЛ

232505091



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 22

Дугаар 101-ХЭА-2025/188/НА-СТА-ТШЗ
А 2390049 Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Ханбүргэд номин ХХК-тай засвар үйлчилгээ хийлгэх гэрээ байгуулан засварын зардлаас 9,500.0 мянган төгрөг, цэвэр бохир усны зардлаас 4,800.0 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгө зарцуулж засварын ажил хийлгэсэн боловч гэрээг дүгнэж, хэрэгжилтийг тайлагнаагүй, засварын ажлын зураг төсөв гаргаагүй, цэвэр бохир усны зардлаас засварын зардал гаргаж батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг баримтлалгүй зардал хооронд шилжүүлэн зарцуулсан байна.

2. Энх антарис мэд ХХК-тай гэрээ байгуулан 6,000.0 мянган төгрөгийн халаалтын зуух худалдаж авсан боловч хөрөнгийг хүлээж авсан акт үйлдээгүй, техникийн ашиглалтын паспорт байхгүй, биет тооллого хийхэд уурын зуух нь эвдэрсэн зэрэг анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, төсвийн хөрөнгийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7.-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Анхан шатны баримтыг бүрдэлгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд тусгаж мөнгөн хөрөнгө зарцуулдаг, төсвийн хөрөнгийг зардал хооронд шилжүүлж зориулалт бус зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зоонозын өвчин судлалын төвийн дарга Ц.Гэрэлмаа, нягтлан бодогч Б.Амгаланбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ж.ГАНБААТАР
Х.ЕРКЕГҮЛ

232504101



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 22

Дугаар 100-ХЭА-2025/188/НА-СТА-ТШЗ
А 2390049 Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлаас байгууллагын дарга хяналт шалгалтын үнэлгээ, санхүүгийн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ зэрэг үзүүлэлтийг үндэслэн 5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буюу 8,360.0 мянган төгрөг, оны шилдэг тасаг, шилдэг ажилтнуудад 6,473.3 мянган төгрөг, нэг өмч-нэг бүртгэл аяны үр дүнг үндэслэн өмч хамгаалах байнгын зөвлөлд 1,017.6 мянган төгрөг, нягтлан бодогчид төрийн болон албаны нууц хамгаалах ажилтны нэмэгдэл 1,425.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан, зардлын эдийн засгийн ангилал зөрчин олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хуульд тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3.2-д "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно", Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам"-ын 1.2-т "Нууц хамгаалах ажилтнаар тагнуулын байгууллагын Аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж тэнцсэн хүнийг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр томилно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн", 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

232504100

1. Урамшуулал давхардуулан олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга Ц.Гэрэлмаа, нягтлан бодогч Б.Амгаланбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ж.ГАНБААТАР
Х.ЕРКЕГҮЛ